



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний зөвлөлийн дүрэм"-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. "Иргэний зөвлөлийн дүрэм"-ийг тухайн Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран байгууллага, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ө.Энхтөр/-д даалгасугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2014 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/89 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан/-д даалгасугай.


С.БЯМБАЦОГТ


Doc/tushaal Said. 2017 он

08 0573

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2017 оны 05 дугаар сарын 19 ны өдрийн
А/133 дугаар тушаалын хавсралт



ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Иргэний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагаанд энэхүү дүрмийг мөрдөнө.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлд "Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 иргэний төлөөлөл бүхий орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байна" гэж заасны дагуу аймаг, нийслэлийн Иргэний зөвлөлийг байгуулан ажиллуулна.

2.2. Зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, сонгохдоо Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлд заасныг удирдлага болгоно.

Гурав. Зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалт

3.1. Зөвлөлийн гишүүнд Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан, иргэн нэр дэвшинэ.

3.2. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Ажлын албаны даргаар ахлуулсан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны хууль зүйн мэргэжилтэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтан, Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн сонгон шалгаруулах комисс /цаашид "Комисс" гэх/-ыг байгуулж, дараах ажлыг зохион байгуулна.

3.2.1. Зөвлөлийн гишүүнд нэр дэвших хүсэлтийг хүлээн авах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон боломжит бүх хэлбэрээр /цахим хуудас, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн Нийтийн Хуралд албан бичгээр хүргүүлэх зэрэг/ иргэдэд мэдээлэх;

3.2.2. Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэхийг хүссэн иргэн нь дараах материалыг бүрдүүлж Комисст ирүүлнэ. Үүнд:

а/ Товч намтар /Төрийн албан хаагчийн анкет/
б/ Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэгт заасны дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх хуудас.

3.2.3. Комисс нь 3.2.1 дэх хэсэгт заасны дагуу иргэдэд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор иргэний нэр дэвших хүсэлтийг бичгээр болон цахим хуудсаар хүлээн

авах;

3.2.4.Комисс нь Зөвлөлд нэрээ дэвшүүлсэн иргэдийн хүсэлтийг хүлээн авч дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор шаардлага хангасан иргэдийн нэрсийн жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар бэлтгэх;

3.2.5.Зөвлөлд нэр дэвшсэн иргэдийн жагсаалт, товч намтарыг 30 хоногийн хугацаанд цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад хэлбэрээр иргэдэд ил тод тавьж, санал авах ажлыг зохион байгуулна. Санал авах ажлыг дараах хэлбэрээр явуулна.

а/цахим хуудсаар;

б/сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаар;

3.2.6.Комисс нь цахим хуудсаар ирүүлсэн санал, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаас ирсэн саналыг 7 хоногийн хугацаанд нягтлан үзэж, хамгийн их санал авсан дарааллаар нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргаж, холбогдох материалын хамт аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

3.2.7.Комиссоос ирүүлсэн материалыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 7 хоногийн дотор хэлэлцэж, Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлд заасныг удирдлага болгон гишүүдийг томилно.

3.3.Зөвлөлийн гишүүнээр томилогдсон иргэн тэр даруй аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас зохион байгуулах сургалтад заавал хамрагдана.

3.4.Зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр чөлөөлнө:

3.4.1.улс төрийн албан тушаалд сонгогдсон, томилогдсон;

3.4.2.хууль сахиулах байгууллагын алба хаагч, прокурор, шүүгчээр томилогдсон;

3.4.3.хуульд заасан ашиг сонирхлын зөрчил тогтоогдсон;

3.4.4.гэм хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

3.4.5.өөрийн биеэр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан,

3.4.6.эрүүл мэндийн шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон;

3.4.7.зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа оролцоогүй;

3.4.8.ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, захиргааны зөрчил санаатай үйлдсэн.

3.5.Энэ дүрмийн 3.4.1-3.4.8 дахь хэсэгт заагдсан үндэслэл тогтоогдсон тохиолдолд зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Зөвлөлийн гишүүнээс чөлөөлнө.

3.6.Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдсөний дараа сул орон тоонд нөхөн томилогдсон гишүүн өмнөх гишүүний бүрэн эрхийг үлдсэн хугацаанд хэрэгжүүлэн ажиллана.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр

- 4.1.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ээлжит болон ээлжит бус хуралдаан байна.
- 4.2.Зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.
- 4.3.Зөвлөл нь тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор дараа жилийн ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулан баталж, цахим хуудсанд байршуулна.
- 4.4.Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга, гишүүд санал болгоно.
- 4.5.Цагдаагийн төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нар Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаар санал ирүүлж болно.
- 4.6.Зөвлөлийн дарга, эсхүл гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.
- 4.7.Зөвлөлийн дарга нь ээлжит хуралдаан болохоос 3, ээлжит бус хуралдаан болохоос 1 хоногийн өмнө хуралдааны хөтөлбөр, хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, танилцуулгыг Зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, гишүүдийг хуралдаан болохоос өмнө мэдээлэлтэй танилцсан байх арга хэмжээ авна.
- 4.8.Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд ирц хүрэлцээгүй тохиолдолд хуралдааныг хойшлуулна.
- 4.9.Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэх бөгөөд санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн дарга эцэслэн шийдвэрлэнэ.
- 4.10.Зөвлөлийн даргын баталсан дэгийн дагуу Зөвлөлийн хуралдааныг явуулна.
- 4.11.Хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хөтөлбөр, холбогдох мэдээллийг хуралдаан болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан цахим хуудсанд байршуулна.
- 4.12.Зөвлөл хагас жилийн ажлын тайлангаа 7 дугаар сарын 10, бүтэн жилийн ажлын тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багтаан цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй мэдээлнэ.
- 4.13.Зөвлөлийн гишүүнд олгосон урамшил, хуралдаанд оролцсон ирцийн мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багтаан цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлнэ.
- 4.14.Зөвлөл нь үйл ажиллагааны явц, үр дүн, хийсэн ажлын талаар аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулж, нийтэд мэдээлнэ.

Тав. Зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.Зөвлөл нь Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1.1.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.6.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд:

а/Зөвлөл нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төсвийн төсөл, зарцуулалт, үйл ажиллагааны болон санхүүгийн холбогдолтой мэдээ, үр дүн, тайлан, түүнчлэн цагдаагийн байгууллагад аудит хийлгэсэн санхүүгийн тайланг ээлжит болон ээлжит бус хуралдаанд сонсоно.

б/ тайлангийн хуралд иргэдийг оролцуулан нээлттэй явуулж болно.

в/Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.8 дахь хэсэгт заасны дагуу Иргэний зөвлөл нь өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон цагдаагийн төв байгууллагын дарга, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тус тус санал, зөвлөмжөө хүргүүлнэ.

5.1.2.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.6.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд:

а/цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын бичиг баримттай танилцаж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөв, хэрэгжилтийн тайланг сонсох;

б/цагдаагийн алба хаагчдын сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад мэргэжилтэн, шинжээч, судалгааны багаар дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах;

в/цагдаагийн алба хаагчдын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй танилцаж, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

г/бусад шаардлагатай асуудлаар тайлан сонсож, холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөх.

5.1.3.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.6.3 дахь хэсэгт заасан эрхийн хүрээнд:

а/цагдаагийн байгууллагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуульд заасан хугацаанд шалгах, шийдвэрлэх, иргэний зөрчигдсөн эрхийг хангах үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг улирал тутам авч, дүн шинжилгээ хийх;

б/тухайн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг судалгааны багаар жил бүр гүйцэтгүүлж, түүнд дүн шинжилгээ хийх;

в/гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны талаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах хайрцаг цагдаагийн байгууллагад байрлуулж, дүн шинжилгээ хийх;

г/бусад шаардлагатай асуудлаар тайлан мэдээ авч, дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх.

5.1.4.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.6.4 дэх хэсэгт заасан эрхийн хүрээнд:

а/цагдаагийн алба хаагч, ажилтны гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, сахилга,

ёс зүйн зөрчилд гаргасан статистик мэдээллийг улирал бүр авч, түүнд дүн шинжилгээ хийж, ажлын чиглэл тодорхойлох;

б/цагдаагийн байгууллагын Төрийн албаны салбар зөвлөл, Ёс зүйн хороотой мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

в/цагдаагийн алба хаагчийн гаргасан ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэх;

г/бусад холбогдох асуудлаар хяналт тавьж, байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөх.

5.1.5.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.6.5 дахь хэсэгт заасан эрхийн хүрээнд:

а/Зөвлөл нь Засаг даргын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, хүргүүлэх;

б/нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд санал өгөх;

в/гомдол, мэдээлэл, өргөдөл, гэмт хэрэг, зөрчлийн талаарх статистикийн мэдээлэлд үндэслэн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд судалгааны багаар судалгаа хийлгэж, санал, зөвлөмж боловсруулан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Цагдаагийн байгууллагад хүргүүлэх;

г/Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.2 дахь хэсэгт зааснаар төсөвт саналаа хүргүүлэх, мөн хуулийн 19.1 дэх хэсэгт заасан хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэх;

д/бусад шаардлагатай асуудлаар санал боловсруулах.

5.2.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсэгт заасан дэмжлэг үзүүлэх үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:

а/тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, хөгжлийн бодлогыг боловсруулахад санал өгөх;

б/гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүний онцлогийг иргэдэд сурталчлах;

в/цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд иргэд, төрийн бус байгууллагын түншлэл, итгэлцлийг сайжруулах, гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоож, туршлага судалж, хэрэгжүүлэх;

г/тухайн нутаг дэвсгэрт ажиллуулах олон нийтийн цагдаагийн ажилтны тоог тогтоох санал, үндэслэлийг цагдаагийн байгууллагатай хамтран жил бүр холбогдох байгууллагаас тогтоосон жишиг нормативын дагуу боловсруулж, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргад хүргүүлж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

д/гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

е/цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, тэдний эрүүл мэндийн болон нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

ж/бусад холбогдох асуудлаар дэмжлэг үзүүлэх.

Зургаа. Зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг

6.1.Зөвлөлийн дарга, гишүүн нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

6.2.Зөвлөлийн дарга, гишүүд нь Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар

зүйлийн 62.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

6.3.Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.7 дахь хэсэгт заасан хориглосон үйл ажиллагааг явуулахгүй байх.

Долоо. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

7.1.Зөвлөлийн төсөв, гишүүдийн урамшлыг Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.10-д заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

Найм. Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг

8.1.Цагдаагийн байгууллага нь Зөвлөлтэй хамтран ажиллах талаар дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

8.1.1.Зөвлөлийн хуралдаанд оруулах санал, түүнтэй холбоотой мэдээлэл, танилцуулгыг хуралдаан болохоос өмнө ажлын 3 хоногийн дотор Зөвлөлд хүргэх;

8.1.2.Зөвлөлийн хуралдаанаас гарсан, хууль тогтоомжид нийцсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд шалтгаан, үндэслэл бүхий хариу өгөх;

8.1.3.Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан эрх, үүргийн дагуу хамтран ажиллах;

8.1.4. Зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах;

8.1.5.Зөвлөлтэй хамтран ажиллах асуудал хариуцсан алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажиллуулж, түүний ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод үүргийг нь нэмж тусгах;

8.1.6.Тухайн цагдаагийн байгууллагын даргын зөвлөлийн гишүүн, зөвлөлтэй хамтран ажиллах асуудал хариуцсан цагдаагийн алба хаагч нь Зөвлөлийн хүсэлтээр хуралдаанд оролцож, тус байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаар тайлбар, хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалд санал өгөх;

8.1.7.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь тухайн жилийн үйл ажиллагааны тайланг байгууллагын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор багтаан Иргэний зөвлөл, оршин суугчдад тайлагнахаар Зөвлөлд хүргүүлэх;

8.2.Зөвлөлтэй хамтран ажиллах үүргийг нутаг дэвсгэр, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, түүний эзгүйд дэд дарга хэрэгжүүлнэ.